

## **Монгол улсын Шүүхийн тухай хуулийн төслийн талаарх цуврал хэлэлцүүлэг №3**

**5 сарын 7, 2020**

### **“Шүүгчийн хариуцлагын асуудал Шүүхийн тухай хуульд туссан байдал” хэлэлцүүлгийн тэмдэглэл**

МУ-ын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Шүүхийн эрх мэдлийн талаар орсон том өөрчлөлт нь шүүгчийн хариуцлагыг нэмэгдүүлэх, хариуцлага тооцох механизмыг үр нөлөөтэй болгох үүднээс Шүүхийн Сахилгын хороог Үндсэн хуульд тухайлан тусгаж өгсөн.

Шүүхийн тухай хуулийн төсөлд энэ талын зохицуулалт өргөн хүрээнд тусгагдсан байгаа. Нэр томъёонууд шинээр орж ирсэн, ойлголт тодорхойлолтуудыг нарийвчлан оруулсан байна.

-Шүүхийн тухай хуулийн төсөлд Шүүгчийн хариуцлагатай холбоотой орж байгаа Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн үзэл баримтлалын дагуу оруулсан зохицуулалтын талаар

#### **Ш.Цолмон:**

Өнөөгийн практикт шүүгчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой 2 өөр хэм хэмжээ, 2 өөр процесс, 2 өөр байгууллага харьяалан шийдвэрлэж байгаа. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дэргэдэх Шүүхийн ёс зүйн хороо, Хуульчдын холбооны дэргэдэх Мэргэжлийн хариуцлагын хорооны аль алинд шүүгчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой маргааны харьяалан шийдвэрлэж байгаа учир давхардал үүссэн байгаа.

Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Шүүхийн эрх мэдлийн талаар орсон том өөрчлөлт нь шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороотой холбоотой зохицуулалт байна. Шүүхийн сахилгын хорооны чиг үүргийг Үндсэн хуулийн 49.6-д заасан байгаа. Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлж Шүүхийн сахилгын хороо бие даан ажиллах эрх зүйн орчныг бий болгож, бүрэн эрх, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, томилох журмын тухай хуульчилж өгснөөс гадна, Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульчилж өгсөн. Эдгээр асуудлын талаар хуулийн төсөлд 2 бүлэг болгон зохицуулсан.

Зарчмын хувьд оруулсан өөрчлөлтийн талаар:

Шүүхийн Сахилгын хорооны бүрэлдэхүүн болон түүнд орох төлөөллийн асуудал. Хууль зүйн Яамны төсөлд бүх талын тэнцвэрт байдлыг хангах үүднээс Шүүхийн сахилгын хорооны гишүүд Шүүгчдийн Зөвлөлөөс 4, Хууль Зүйн Байнгын хорооноос 3, Ерөнхийлөгч болон Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс тус бүр 1, 1 хүнийг сонгож нээлттэй сонгон шалгаруулахаар зохицуулсан. Шүүхийн Сахилгын хорооны орон тоог 9 байхаар Үндсэн хуульд тусгасан. Орон тооны, орон тооны бус асуудал тодорхойгүй байсныг Шүүхийн сахилгын хорооны төсвийн асуудалтай холбоотой болон Шүүхийн сахилгын хорооны жилд шийдвэрлэж байгаа хэргүүдийн ачааллыг харгалзан 3 нь орон тооны, 7 нь орон тооны бус байхаар зохицуулсан.

Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сахилгын зөрчлийн таларх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах, хянан шийдвэрлэх, давж заалдах журмаар гомдол гаргах,

шийдвэрлэх ажиллагаанаас бүрдэхээр хуульчилсан. Түүнчлэн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх процессыг маш тодорхой болгосон. Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шат дамжлагыг багасгах зорилгоор Шүүхийн сахилгын хороо иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол мэдээллийг 60 хоногийн дотор шалгаж, хянаж шийдвэрлэнэ. Илтгэгч гишүүн буюу гомдол мэдээллийн хүлээн авах гишүүн гомдол, мэдээллийг хүлээн авснаас 30 хоног дотор шалгана. Сахилгын хэрэг үүсгэх болон сахилгын хэрэг үүсгэхээс татгалзах захирамж гаргахаар зохицуулсан. Энэхүү захирамжийг хэргийн оролцогчид эс зөвшөөрвөл Шүүхийн сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцэхээр тусгасан. Ингэхдээ илтгэгч гишүүнээс гадна, 5-аас доошгүй гишүүний ирцтэйгээр хуралдаж сахилгын хэргийг 30 хоногийн дотор хянан шийдвэрлэж магадлал гаргахаар тусгасан.

Илтгэгч гишүүн тухайн хэргийн талаар шалгалтын дүнг хуралдаанд танилцуулах боловч хэргийг эцэслэн шийдвэрлэхэд оролцохгүйгээр зохицуулсан.

Сахилгын хэргийг эцэслэн шийдвэрлэж байгаа тохиолдолд Сахилгын хороо магадлал, сахилын хэрэг үүсгэхээс татгалзсан захирамж болон хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бусад асуудлаар тогтоол гаргахаар тусгаж тогтоол нь эцсийн шийдвэр байхаар зохицуулсан.

Харин сахилгын хэргийг эцэслэн шийдвэрлэсэн Шүүхийн сахилгын хорооны магадлалд гомдол гаргах эрхтэй байхаар хуульчилж магадлалыг эс зөвшөөрвөл Улсын Дээд Шүүхэд гомдол гаргахаар, Улсын Дээд Шүүх 5 гишүүнтэйгээр танхим харгалзахгүйгээр 30 хоногийн дотор шийдвэрлэхээр зохицуулсан.

Сахилгын хорооны ажлын алба ажиллана. Энэ албанд сахилгыг хэргийг хянаж шалгах нэгж байхаар зохицуулсан.

Шүүгчийн сахилгатай холбоотойгоор шүүгчид ёс зүйн зөрчлөөс гадна мэргэжлийн хариуцлагын асуудал яригдаж байгаа. Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон хуулийн тодорхой заалтыг ноцтой зөрчсөн, илтэд буруу хэрэглэсэн бол мэргэжлийн хариуцлага хүлээх асуудал яригддаг. Ингэж байж иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, баталгаатай байдлыг бий болгоно.

**Шүүгчийн мэргэжлийн хариуцлагатай холбоотой зохицуулалт нь шүүгчийн ажил хэргийн чадварын талаар дүгнэлт гаргуулахаар дээд шатны шүүх нь тогтоол гаргаж Мэргэжлийн хороонд хүргүүлэх заалт юм. Энэ тогтоолыг үндэслэн Мэргэжлийн хороо ажил хэргийн мэдлэг, чадварыг үнэлсэн дүгнэлт гаргах юм. Үндэслэл бүхий тогтоол гарсан гэж дүгнэгдвэл Шүүхийн Ерөнхий Зөвлөлд хүргүүлж зохих журмын дагуу шийдвэрлэнэ.**

***Төслүүдэд тусгагдсан шүүгчийн хариуцлагын зохицуулалтын талаар санал, шүүмж:***

**О.Мөнхсайхан:**

Шүүхийн сахилгын процесс бол шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах болон шүүгчийн хариуцлагын асуудлыг зохицуулдаг. Шүүгч зүй бус нөлөөнд автахгүй, хараат бус байх баталгаагаар хангагдах ёстой. Хараат бус байдал болон шүүгчийн хариуцлага 2-г тэнцвэржүүлэх зорилготой байдаг. шүүгчийн хараат бус байдал гэдгээр шүүгчийн

хариуцлагыг хаацайлах, өөгшүүлж болохгүй. Нөгөө талаас шүүгчийн хариуцлага нэрээр хараат бус байдал руу халдаж болохгүй.

Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Шүүхийн Ерөнхий Зөвлөл Шүүхийн Сахилгын хорооны үйл ажиллагаанд оролцохгүй, бие даасан үр нөлөөтэй тогтолцоог бий болгох зорилгоор Сахилгын хороог байгуулах зохицуулалтууд орсон байна. 2 төсөлд бие даасан Шүүхийн сахилгын хороог бий болгох үзэл баримтлал байгаа. Шүүхийн сахилгын хорооны бүтэц бүрэлдэхүүн, тэдэнд тавигдах шаардлага, хориглох зүйл, ажлын алба, маргаан шийдвэрлэх процесс зэргийг хуульд нарийвчлан оруулсан нь сайн талтай.

Бүрэлдэхүүний хувьд 2 төсөл өөр зохицуулалт хийсэн. Хууль зүйн яамны төсөлд 9 гишүүнтэй байхаар, Шүүгчдийн зөвлөлөөс 4, Хууль Зүйн байнгын хорооноос 3, Ерөнхийлөгч 1, Хууль зүйн сайд 1-ийг нээлттэйгээр сонгон шалгаруулж томилохоор зохицуулсан. Даргаа өөрсдөө дотроосоо сонгоно гэсэн нь Шүүхийн сахилгын хорооны бие даасан хараат бус байдлыг бий болгосон. 4 гишүүнийг Шүүгчдээс сонгож байгаа нь улс төрийн зүй бус нөлөөллийг багасгах талтай. Хууль зүйн Байнгын хорооноос 3 гишүүнийг санал болгож УИХ-н нийт гишүүний 3-ны 2-оор томилох зохицуулалт орсон нь Парламентын олонх цөөнхийн балансыг барих чухал зохицуулалт.

Ерөнхийлөгч Шүүхийн Сахилгын хорооны 1 гишүүнийг томилох асуудал 2 төсөлд байгаа. Үүнтэй санал нийлэхгүй байна. Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Ерөнхийлөгчид заагаагүй бүрэн эрхийг олгохын хориглосон учир Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй нийцэхгүй. Ерөнхийлөгч томилох асуудлыг хаах ёстой.

Ерөнхийлөгчийн өргөн барьсан төсөлд Шүүхийн сахилгын хороо 12 гишүүнтэй байна. 3-г Ерөнхийлөгч, 3-г Хууль Зүйн Яам, 3-г Хуульчдын холбоо, 3-г Шүүгчдийн зөвлөл нэр дэвшүүлж УИХ томилохоор заасан. Сайн тал нь мэргэжлийн хороог оруулж ирсэн асуудал болон УИХ томилохдоо томилгооны сонсгол хийх зохицуулалт орсон байна. 3-г нь Ерөнхийлөгч томилох асуудал нь Үндсэн хуультай зөрчилдөж байна. Үндсэн хуулиар Ерөнхийлөгчид олгоогүй бүрэн эрхийг олгосон асуудал болж байна.

Мөн шүүгч нар сахилгын маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүнийг Ямар нэгэн улс төрийн дамжлагаар орохгүйгээр шууд сонгодог байх ёстой. Хараат бус байдалд халдах боломжтой юм.

Санал болгох:

Яамны төслөө голлож, Ерөнхийлөгчийн төслөөс зарим нэг зохицуулалтыг авах. Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүний 4-г Шүүгчдийн зөвлөл шууд сонгох, 4-г УИХ сонгон шалгаруулж томилох, 1-г ХЗ-н сайд томилох, Ерөнхийлөгчийн оролцоо байж болохгүй.

Шүүгч биш гишүүдийн 4-г их хурал томилохдоо Парламент нээлттэйгээр сонгон шалгаруулах, 3-ны 2-оор сонгох томилох жишиг олон улсад байдгийг оруулах нь зөв.

Ерөнхийлөгчийн төслөөс томилгооны сонсгол хийх зохицуулалтыг оруулах нь зүйтэй.

Шүүхийн сахилгын хорооны шүүгч гишүүд Шүүхийн Сахилгын хорооны цөөнх байх ёстой буюу 4 нь хамгийн тохиромжтой, 5 гишүүн нь шүүгч биш байх ёстой. Хөндлөнгийн

бүрэлдэхүүн хянаж байх нь зөв. Сахилгын хорооны шийдвэрийг Дээд шүүхээр хянаж байгаа нь хараат бус байдал, хариуцлагын асуудлын балансыг барина.

**Өнөөгийн практикт тулгамдаж буй асуудлыг төслүүдэд шийдэл болгон зохицуулсан зохицуулалт орж чадсан эсэх талаар:**

**А.Бямбажаргал:**

ҮХ-н нэмэлт өөрчлөлтөөр ҮХ-ийн 49.6-д

1992 оны Үндсэн хуулиар сахилгын шийтгэл оногдуулах чиг үүргийг хэн хэрэгжүүлэх талаар зохицуулаагүй байсан. 1993 оны Шүүхийн тухай хууль нь шүүх талдаа олгосон. Дараагийн хууль нь Яамд олгосон байсан. 2012 оны Шүүхийн багц хуулиудад бие даасан шинжтэйгээр зохицуулсан ч Шүүхийн Ерөнхий Зөвлөлтэй чиг үүрэг давхардуулсан байсан.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр эрх зүйн хувьд цоо шинэ нөхцөл байдал бий болсон. Шүүх эрх мэдэл хараат бус бие даасан байх ёстой бөгөөд хариуцлагатай байх механизм доголдвол асуудал үүсдэг. Шүүгчийн хариуцлагын асуудал үр нөлөөгүй байна гэсэн асуудал их яригдаж, туссан байгаа. 2019 оны өөрчлөлт Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн тусдаа чиг үүрэгтэй Шүүгчийн хариуцлагын асуудлыг зохицуулдаг бие даасан хороог гаргаж ирсэн.

Үндсэн хуульд Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүний асуудлыг хуулиар тогтоож болно гэж зохицуулагдсан. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл хэлэлцэх явцад 9 гишүүнтэй байхаар яригдаж байсан. Хууль Зүйн яамнаас өргөн барьсан төсөлд 9 гишүүний тоог барьсан байна.

Судлаачийн хувьд 3 гишүүнийг орон тооны байхаар зохицуулсантай санал нийлэхгүй байна. Гишүүдийг хараат бус байлгахын тулд үндсэн ажлынхаа хажуугаар хавсарга байдлаар хийвэл маргааныг бүрэн шийдвэрлэж чадах эсэх асуудал гарч ирнэ.

Тодруулах шаардлагатай зохицуулалт:

Зөвлөлүүдийг бүрдүүлэхийн тулд олон төлөөлөл оруулдаг шалтгаан нь балансжуулах зорилготой байдаг. Шүүгч нар шүүгч нараа хаацайлах асуудал гардаг. Бие даасан хороо бүхий зохицуулдаг улсуудын хувьд зайлшгүй шүүгч нарыг оруулах ёстой, мөн парламентын оролцоо байх ёстой ард түмнийг төлөөлж байгаа гэдэг үүднээс.

Шүүхийн Сахилгын хорооны гишүүнийг санал болгох эрх хэмжээг Ерөнхийлөгчид олгож байгаа нь Үндсэн хуультай зөрчилдөж байна.

**Үзэгчдийн асуулт:**

-Хууль яамны төслөөс сахилгыг хэргийн бүх шатны шүүхээр хэлэлцэж шийдвэрлэж дуусах хүртэлх хугацаа 60 хоног байх нь боломжгүй, хугацаа шаардагдана гэсэн санал

-Шүүгчээс өөр хуульч маргаан шийдвэрлэх боломжгүй гэж үзэж байна уу? яагаад шүүгч нар цөөнх байна гэдэг байр суурьтай байна вэ?

-Шүүхийн Сахилгын хорооны шийдвэрийг олон шатаар дамжиж хянах бус шууд Дээд шүүх, захиргааны танхим гэхээс илүү бүх шүүгчдээс 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэх боломжтой юу?

Хугацааны асуудалтай холбоотой асуудлуудын талаар:

### **Ш.Цолмон:**

Сахилгын хэрэг маргааныг 30 хоногийн дотор шалгана, шаардлагатай бол 30 хоногоор сунгах боломжтой. Нийт хэрэг хянан шийдвэрлэх хугацаа 60 хоног, давж заалдах журмаар Дээд шүүх 30 хоног, нийт 90 хоног.

### **О.Мөнхсайхан:**

Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүний олонх нь шүүгч биш байх ёстой гэдэгтэй санал нэг байна. Төслүүд тийм байгаа. Шүүгч ёс зүйтэй байна уу гэдгийг шүүгч нар олонхоороо шийдвэрлэх нь бие биенээ хаацайлах асуудал практикт гардаг. Ерөнхийлөгчийн төсөл дээр шүүгчдийн төлөөлөл шүүгчдээс шууд томилогдохгүй, УИХ-аар томилдог байх гэсэн зохицуулалт нь ноцтой байна. Шүүхийн сахилгын хорооны шийдвэр нь 4-ний 1 нь шүүгч 4-ний 3 нь шүүгч биш бүрэлдэхүүнтэйгээр шийдэж болно. Энэ нь хэргийг эцэслээд шийдчихвэл шүүгчийн хараат бус байдал үгүйсгэгдэнэ. Манайх шиг загвартай, ийм хороогоор хөндлөнгийн бүрэлдэхүүн шийдвэрлэдэг. Америкт 9 гишүүний 3 нь хуульч, 3 нь иргэн, 3 нь шүүгч байдаг. Европт мөн олонх шүүгч биш хүмүүс байж, шийдвэрлэж маргаан гарвал Дээд шүүх хянадаг. Балансыг барих үүднээс Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүн нь хөндлөнгийн байна, хараат бус байдлыг хангах үүднээс Дээд шүүхэд хянуулахаар Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд бичсэн байсан.

Орон тооны, орон тооны бус асуудалд дээр Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнийг Үндсэн хууль тусгайлан заагаагүй. Шүүхийн Сахилгын хорооны орон тооны, орон тооны бус асуудлыг хуулиар шийдвэрлэх боломжтой гэсэн үг. Ачааллын асуудал дээр 9 орон тооны хүн бүрэн шийдвэрлэх ачаалал байна уу үгүй юу гэдгийг судлах шаардлагатай.

Шүүхийн Сахилгын хороонд өндөр мэргэшилтэй хүн байх ёстой юм. Үндсэн хуулийн Цэц, Шүүхийн Ерөнхий Зөвлөл өндөр мэргэшилтэй хүн байдаг бөгөөд орон тооны гишүүд байдаг. Орон тооны бус 9 хүн олдох үгүй нь эргэлзээтэй, хүний нөөцийн асуудал. Бүгд орон тооны байх эсэх дээр Яамны төсөл зүгээр санагдсан. Хамгийн гол нь орон тооны 3 нь орон тооны бус 6-аас давуу эрхтэй биш байхаар зохицуулалт хийгдэх ёстой.

### ***Орон тооны байх талаар***

### **А.Бямбажаргал:**

Хүний нөөцийн асуудал үүсэж болзошгүй байгаа. Засгийн газрын төслийн 100.3 дахь зохицуулалтыг хууль зүйн бичилтээс нь харахад хуульд заасан бүх шаардлагыг хангасан хүн гэж ойлгогдохоор байгаа учир тодорхой зааж өгөх ёстой.

2014-2018 оны хооронд Шүүхийн Ёс зүйн хороонд жилд дунджаар 280 орчим гомдол ирдэг. Гомдол бүр дээр процессын ажиллагаа явагдана. Тэмдэгтийн хураамж, процесс ажиллагааны саармагжуулах зүйл байхгүй. Тэгэхээр гомдол мэдээлэл өсөх магадлалтай

байгаа. Мөн 3 гишүүн нь орон тооны байна гэхээр орон тооны болон орон тооны бус гишүүдийн зааг ялгаа гардаг. Үүнийг зохицуулах шаардлагатай. Бүрэн цаг заваа зориулж чадахгүй байвал орон тооны гишүүд орон тооны бус гишүүдийг дагаж санал өгөх асуудал гарч ирдэг.

Хуулийн төслүүдэд процессын заалтуудыг оруулсан гэх боловч бодит байдал дээр маргаан шийдвэрлэж байгаа гэдгээр харвал бага зохицуулсан харагдаж байна. Нэгэнт хуулиар зохицуулаагүй бол практик жишгээр явах магадлал өндөрсөнө.

### **Ш.Цолмон:**

Хөөн хэлэлцэх хугацааны хувьд хуулийн төслийн 59.2-т заасан байгаа. Сахилын зөрчлийн талаарх олон улсын туршлагаар хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэдэггүй, хэрэглэдэг зохицуулалт байдаг. Төсөл дээр сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 12 сараас илүү хугацаа өнгөрвөл шүүгчид сахилгын шийтгэл оногдуулж болохгүй гэж одоогийн хөөн хэлэлцэх хугацааг ихэсгэж заасан.

### **О.Мөнхсайхан:**

Хууль зүйн яамны төсөлд сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 12 сараас илүү хугацаа өнгөрвөл шүүгчид ямар ч сахилгын шийтгэл оногдуулахгүйгээр зохицуулсан байна. Ерөнхийлөгчийн төсөлд зөрчил гарснаас хойш 6 сар, илрүүлснээс хойш 24 сар өнгөрсөн бол хариуцлага хүлээхгүй гэж хугацааг урт болгож зохицуулсан.

Хараат бус байдал, хариуцлага 2-н тэнцвэрийг бүх зүйл дээр харах ёстой. Монгол улсад 28 жилийн хугацаанд шүүгчийн сахилын хамгийн ноцтой зөрчлүүд хөөн хэлэлцэх хугацаагаар хаагдсан. Хуулиудад 1 жил гэх хугацаагаар зохицуулагдсан байдаг. Хөөн хэлэлцэх хугацаанаас болоод шүүгч нарын сахилгын хариуцлагыг шийдэж чадахгүй байгаа нь шүүхэд итгэх итгэлийг унагаадаг.

Олон улсын туршлагаар хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй байхаар эсвэл маш урт хугацаагаар тавих ёстой. Жишээлбэл, Польш улсад зөрчил гарснаас хойш 5 жил гэж заасан. Эрх ямба хараат бус байдлын асуудал хариуцлагын асуудалтай хамт явах ёстой. Дээд шүүхээр хянах учир хараат бус байдалд халдах боломжийг хаасан байгаа. Өмгөөллийн хуулиар өмгөөлөгч сахилгын шийтгэл гаргаснаас 3 жил өнгөрсөн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа дуусахаар заасан. Шүүгч нарт үүнээс 3 дахин бага хөөн хэлэлцэх хугацааг заах нь Үндсэн хуультай зөрчилдөнө.

### **А.Бямбажаргал:**

Хөөн хэлэлцэх хугацааг зохицуулж байгаа бол бага хугацаагаар зохицуулах ёсгүй. Хөөн хэлэлцэх хугацаа процесстой холбогддог. Маргаан хянан шийдвэрлэх явцад хөөн хэлэлцэх хугацаа дуусдаг асуудал байдаг. Үүнийг аль аль талдаа шийдвэрлэх шаардлагатай байна.

### **Мэргэжлийн хариуцлагын асуудлын талаар:**

А.Бямбажаргал:

Төслийн 58-р зүйл эргэлзээтэй, Мэргэжлийн хороо Үндсэн хуулийн хүрээнд энэ чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага биш.

Ёс зүйн илэрхий алдаа гарвал яах вэ гэдэг асуудал чухал

Ёс зүйн илэрхий зөрчил гэж шийдвэрлэсэн ч байна, мэргэжлийн алдаа байна гэж шүүхүүдээс хэрэгсэхгүй болгосон тохиолдол байдаг. Шүүгч хэнд ч ойлгомжтой илэрхий алдааг дахин дахин гаргаад байгаа нь шууд ёс зүйн зөрчил гэж үзэж шийдвэрлэдэг олон улсын практикийг барьж зохицуулах нь зүйтэй. Дээд шатны шүүх гэдэг захиргааны бүтцээр буюу Мэргэшлийн хорооны дүгнэлтээр шийтгэл оногдуулдаг байж болохгүй. Хууль Зүйн яамны төсөлд Дээд шүүх хянахаар Үндсэн Хуулийн үзэл баримтлалын дагуу оруулж ирсэн байна. Гомдлыг хянан шийдвэрлэх процессын асуудлууд тодорхой тусгагдаагүй. Захиргааны процессын хууль дээр энэ зохицуулалтууд байхгүй. Шүүхийн бус байгууллагыг Шүүхийн байгууллага хянахаар шүүхтэй адилтгах асуудал гардаг. Гэтэл Шүүхийн Сахилгын хорооны гишүүдэд процессын эрхүүдийг олгоогүй байж Дээд шүүхээр хянуулах нь нөхцөл байдлыг улам дордуулна.

Хэргийг хянаж эхлэхээр хэсгийг түдгэлзүүлэх буюу хөөн хэлэлцэх хугацаа зогсох асуудлыг зохицуулаагүйгээс давхар хөөн хэлэлцэх хугацаа тооцогдож дуусдаг.

### **О.Мөнхсайхан:**

Хууль Зүйн яамны төслийн процессын зохицуулалт сайн болсон байна гэж харж байна. Сахилгын хорооны гишүүн хянаана, хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэнэ, 5-аас доошгүй сахилгын хорооны бүрэлдэхүүн шийднэ, дээд шүүхэд гомдол гаргахаар зохицуулсан байна.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж Шүүхийн Сахилгын хорооны гишүүн нотлох баримт гаргуулах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр төсөлд заасан байна. Гишүүний үйл ажиллагаанд саад учруулсан бол иргэнийг 400 мянга, хуулийн этгээд үйлдвэл 4 сая төгрөгөөр торгох зохицуулалт оруулсан.

Ерөнхийлөгчийн төсөл дээр хүндрүүлсэн 3 шатаар явахаар болсон байна. Гишүүн эхлээд шийдвэрлэнэ, давах шатанд 3, хяналтын шатанд 5 гишүүнтэйгээр шийдвэрлэхээр заасан. Бүрэлдэхүүн давхардахгүй байгаа ч тухайн байгууллага дотроо хянах нь давж заалдах эрхийг хангахгүй Үндсэн хуулийн зөрчил болно. Шүүгчийн хараат байдал руу орсон зохицуулалт байна.

Хууль зүйн яамны төслийн мэдлэг ур чадварын асуудал дээр тэнцэх эсэх асуудлыг Шүүхийн мэргэжлийн хороонд хандаж, Мэргэжлийн хороо тэнцэхгүй байна гэж үзвэл Шүүхийн Ерөнхий Зөвлөлд хандаж шийдвэрлэхээр байна. Энэ зохицуулалт Хаана ч байхгүй зохицуулалт бөгөөд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй нийцэхгүй.

Чөлөөлөх, Огцруулах хоорондоо ялгаатай. Чөлөөлөх гэдэг бол гэм буруугүй байх асуудал, огцруулах гэдэг бол буруутай үйл ажиллагаатай холбоотой.

Илэрхий зөрчлийн шийдэх гарцан дээр Хууль Зүйн яамны төсөлд эргэлзэж байна. Анхан шатны шүүгчид зориулсан зохицуулалт болчихсон, анхан шатны шүүхийн шүүгч нарын хараат бус байдалд халдах зохицуулалт.

Шүүгчийн мэргэжлийн ур чадварын асуудлыг Мэргэжлийн хороо шийдвэрлэх боломжгүй: Мэргэжлийн хороо шалгалт авах үүрэгтэй байгуулагдсан болохоос буруутгагдаж байгаа шүүгчийн процессын эрх байхгүй. Нотлох баримт цуглуулах, тайлбар хэлэх гэх мэт.

Шүүгчийн илэрхий мэргэжлийн алдааны зарим нь сахилгын шийтгэл болдог. Шүүгчийн сахилгын зөрчлийг хуульд тодорхой жагсааж зааж өгсөн улсууд байдаг. Энэ шүүхийн Сахилгын хороо дур зоргоор шийдвэрлэхгүй зэрэг сайн талтай. Яамны төсөлд шүүгчид хориглох зүйлсийг жагсаая гэсэн санал байна.

Шүүхийн Сахилгын хорооны процессын асуудлыг хуулинд тусгасан байгаа учир Сахилгын хороо буруу шийдвэрлэлээ гэхэд Дээд шүүх хянах учир шүүгчийн хараат бус байдалд халдахгүй. Практикт Шүүхийн ёс зүйн хороо удаа дараагийн илэрхий алдааг ёс зүйн шийтгэл оногдуулсан. Дээд шүүх бас мэргэжлийн алдаа биш, сахилгын шийтгэл гэж шийддэг. Мөн бүх шүүгчийн асуудал Шүүхийн сахилгын хороонд очих боломжтой. Шүүгчийн буруутай үйл ажиллагаа учир сахилгын шийтгэл байх ёстой, огцруулах асуудлыг Шүүхийн Сахилгын хороо шийдвэрлэх ёстой, Мэргэжлийн хороонд өгөх нь буруу.

### **Ш.Цолмон:**

Мэргэжлийн хариуцлагын асуудлын талаар

Мэргэжлийн хороонд хариуцуулах уу Шүүхийн сахилгын хороонд хариуцуулах уу гэх талаар хэлэлцсэн. Мэргэжлийн ур чадварын асуудлыг Дээд шатны шүүх л тогтоох учиртай гэсэн дүгнэлтэд хүрсэн. Мэргэжлийн бус субъект тогтоох нь учир дутагдалтай. Дээд шатны шүүх тогтоол гаргаж, Мэргэжлийн хороо дүгнэлт гаргаж ШЕЗ-д хүргүүлэхээр болсон байгаа.

Нотлох баримт гаргуулах, үнэлэхтэй холбоотой асуудал тусгагдсан байгаа. Төслийн 102.1.1-д Сахилгын хорооны гишүүний бүрэн эрхэд тусгасан байгаа.

-ярилцсан асуудал нь:

Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд Шүүхийн Сахилгын хорооны бүрэлдэхүүний асуудал, бүрэлдэхүүн, түүний тэнцвэртэй байдал чухал. Шүүгч гишүүд цөөнх байх ёстой. Олон төлөөллөөс оруулах нь чухал юм. Шүүгчээр Шүүхийн Сахилгын хороонд ажиллах гэж байгаа шүүгч нар УИХ-аар дамжихгүй шууд томилогддог байх.

Хөөн хэлэлцэх хугацааны асуудал 12 сар буюу 1 жилийн хугацаа нь маш бага байгаа нөхцөл байдал байсаар байна. Олон улсын туршлага бусад хөөн хэлэлцэх хугацаанаас бага байгаа гэдгийг хууль тогтоогчид анхаарах шаардлагатай байна.

Мэргэжлийн алдаатай холбоотой асуудлыг Дээд шатны шүүхээс дүгнэлт гаргаж шийдвэрлэх нь хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх юм.



